



**ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2015 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 01/79

Өгөөмөр

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын  
санаачилгын сумын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.5 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээллэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий сумын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Б.Золбоо /Засаг даргын орлогч/

Гишүүд: Б.Цогнэмэх /Татварын хэлтсийн дарга/

Ү.Наранбямба /Газрын харилцаа, барилга, хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн/

Б.Батсайхан /Уул уурхай, дэд бүтэц хариусан мэргэжилтэн/

Ж.Одхүү /Байгаль орчны бодлогын мэргэжилтэн/

Ш.Отгонбаяр /Байгаль хамгаалагч/

Х.Гэрэлмаа /Иргэний байгууллагын төлөөлөл/

Д.Одгэрэл /Иргэний байгууллагын төлөөлөл/

Нарийн бичиг: В.Хүүхэндүү /Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч/

2. Суманд ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компани, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн орлогын тайлан болон Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар байгуулсан гэрээ, түүний тухайн жилийн хэрэгжилтэнд хяналт тавьж, дараа оны 2 дугаар улиралд нийтэд мэдээллэхийг сумын Зөвлөл /Б.Золбоо/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.СОДБААТАР